


НИЙГМИЙН ХӨГЖИЛД НИЙСЛЭЛ ХОТЫН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

Монгол улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын 45.1 хувь буюу бараг 2 хүн тутмын нэг нь нийслэл хотод оршин сууж байна. Нийслэлийн хүн амын 95.0 хувь нь төвийн 6 дүүрэгтээ, тодруулбал зүүн хэсэгт орших Баянзүрх дүүрэгт 23.7 хувь, баруун хэсэг Сонгинохайрхан дүүрэгт 22.9 хувь, хотын төв Баянгол дүүрэгт 15.5 хувь, баруун өмнөд хэсэгт орших Хан-Уул дүүрэгт 11.6 хувь баруун хойт хэсгийн Чингэлтэй дүүрэгт 11.4 хувь, зүүн хойт хэсгийн Сүхбаатар дүүрэгт 9.9 хувь, үлдсэн 5.0 хувь нь Налайх, Багануур, Багахангай дүүрэгт тус тус амьдарч байна.

Зураг 1. Монгол улсын хүн ам, бүсээр



Зураг 2. Хүн амын тархалт, дүүргээр




2000 онд нийслэлийн нэг км² нутаг дэвсгэрт 162 хүн оршин сууж байсан бол 2001 онд 168 хүн, 2002 онд 175 хүн, 2003 онд 185 хүн, 2004 онд 195 хүн, 2005 онд 202 хүн, 2006 онд 210 хүн, 2007 онд 218 хүн, 2008 онд 227 хүн, 2009 онд 235 хүн, 2010 онд 247 хүн, 2011 онд 252 хүн, 2012 онд 259 хүн, 2013 онд 269 хүн, 2014 онд 279 хүн, 2015 онд 286 хүн, 2016 онд 294 хүн оршин суух болжээ. Улаанбаатар хотын хүн амын нягтрал 2013-2016 оны хооронд 9.3 хувиар өсчээ.

Хүснэгт 1. Суурин хүн амын тоо, хүн амын нягтрал, дүүргээр

Дүүрэг	Нутаг дэвсгэр /км ² /	Хүн амын тоо /мян.хүн/				Хүн амын нягтрал, нэг км ² -д			
		2013 он	2014 он	2015 он	2016 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Нийслэлийн дүн	4704.4	1267.0	1314.5	1345.5	1380.8	269	279	286	294
Баянзүрх	1244.1	304.3	308.7	320.9	327.1	245	248	258	263
Сонгино хайрхан	1200.6	277.3	295.8	307.2	315.8	231	246	256	263
Баянгол	29.5	200.2	208.9	205.7	214.3	6785	7081	6975	7264
Хан-Уул	484.7	131.1	138.4	151.0	159.5	270	285	312	329
Чингэлтэй	89.3	155.9	159.5	154.8	158.0	1745	1786	1733	1769
Сүхбаатар	208.4	133.3	136.4	137.6	136.6	640	655	660	655
Налайх	687.6	33.2	34.6	35.8	36.4	48	50	52	53
Багануур	620.2	27.9	28.3	28.4	29.0	45	46	46	47
Багахангай	140.0	3.8	3.9	4.1	4.1	27	28	29	30

Хүн амын нягтрал Баянгол /7266/, Чингэлтэй /1769/, Сүхбаатар /655/ дүүрэгт хамгийн их буюу нийслэлийн дунджаас 2.2-24.8 дахин их байна. Харин захын 3 дүүрэг Налайх /53/, Багануур /47/, Багахангай /30/-д хүн амын нягтрал хамгийн бага байгаа юм.

Зураг 3. Хотуудын хүн амын эзлэх хувь



Улаанбаатар хот Монгол улсын нутаг дэвсгэрийн дөнгөж 0.3 хувийг эзэлж, хүн амын нягтралаар хамгийн өндөр хот хэвээр байна.

Монгол улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын 66.2 хувь буюу 2076.9 мянга нь хотын хүн ам буюу аймгийн төв, нийслэл, тосгоны хүн ам юм. Хотуудын хүн амын 66.4 хувь буюу гуравны хоёр хувь нь нийслэл Улаанбаатар хотод оршин сууж байна.

Нэг км² газарт ногдох хүний тоо буюу хүн амын нягтрал нийслэл хотод 294 хүн байгаа нь Монгол улсын томоохон суурин газар болох Орхон

/нягтрал 117/, Дархан-Уул /нягтрал 30/ аймгаас даруй 2.3-9.6 дахин их нягтралтай байна.

Хүснэгт 2. Нийслэлийн хороод, хүн амын тоогоор

Бүлгийн интервал	Бүлэгт хамаарах хорооны тоо	Бүлгийн хүн амын тоо	Дүнд эзлэх хувь
600-5000	23	84263	6.1
5001-6500	23	134721	9.8
6501-8000	23	163597	11.8
8001-10000	25	218326	15.8
10001-12000	24	264523	19.2
12001-15000	19	250999	18.2
15001+	15	264363	19.1

Нийслэл хот засаг захиргааны анхан шатны 152 нэгжтэй болсноор нэг хороонд дунджаар 9084 хүн оршин сууж байгаа нь нийслэлээс бусад аймгуудын нэг сумын дундаж хүн амын тооноос 1.8 дахин илүү байна.

Нэг хороонд оршин суух дундаж хүн амын тоо 9084 болж өмнөх оноос 232 хүнээр илүү болжээ. Нэг хороонд оршин суудаг хүн амын тоогоор Хан-Уул, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүд тэргүүлж байна. Нийслэл хотын хамгийн их хүн амтай Хан-Уул дүүргийн 15-р хороонд 22229 хүн, харин хамгийн бага хүн амтай Багануур дүүргийн 2-р хороонд 670 хүн оршин

суудаг.

Хүснэгт 3. Хүн амын цэвэр өсөлт

		2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Улаанбаатар	Төрсөн хүүхдийн тоо	30226	33324	36421	37672	42790	39074
	Нас барсан хүний тоо	7768	7554	7068	7608	7245	7275
	Хүн амын цэвэр өсөлт	22458	25770	29353	30064	35545	31799
Улсын дүн	Төрсөн хүүхдийн тоо	69853	73839	79780	82839	82130	79920
	Нас барсан хүний тоо	19155	17761	17247	16521	17620	17763
	Хүн амын цэвэр өсөлт	50698	56078	62533	66318	64510	62157
Цэвэр өсөлтөд нийслэл хотын эзлэх хувийн жин		44.3	46.0	46.9	45.3	55.1	51.1

2016 онд Улаанбаатар хотод 37508 эхээс, 39074 хүүхэд төрж, 7275 хүн нас барж, ердийн цэвэр өсөлтөөр 31799 хүнээр нэмэгдсэн байна. Цэвэр өсөлтөд нийслэл хотын эзлэх хувийн жин 2010 оны байдлаар 43.9 хувьтай байсан бол жил ирэх тусам нэмэгдсээр 51.2 хувьтай болоод байна.

Төрөлтийн ерөнхий коэффициент буюу 1000 хүн амд ногдох төрөлт 27.5 болж 2011 оноос 3.6 промилээр өсч, харин нас баралтын ерөнхий коэффициент буюу 1000 хүн амд ногдох нас баралт 5.0 болж 2011 оноос 1.1 промилээр буурчээ.


Улаанбаатар хотод 2016 онд 39074 хүүхэд мэндэлсэн нь 2011 оноос 8848 хүүхдээр буюу 29.3 хувиар илүү байна.

Хүснэгт 4. Төрөлтийн тоо, эхийн насны бүлгээр, 2011-2016 он

Насны бүлэг	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
15-19	962	1104	1159	1071	1748	1496
20-24	9524	9993	9948	8363	9985	8331
25-29	9855	10848	11908	12025	14027	13311
30-34	5625	6670	7208	8855	10018	9289
35-39	3399	3755	4829	5272	5595	5206
40-44	780	888	1203	1809	1368	1367
45-49	81	66	166	277	49	74
Нийт	30226	33324	36421	37672	42790	39074

Нийт төрсөн хүүхдийн 3.8 хувь буюу 1496 нь 19 хүртэл насны эхээс, 21.3 хувь буюу 8331 нь 20-24 насны эхээс, 34.1 хувь буюу 13311 нь 25-29 насны эхээс, 23.8 хувь буюу 9289 нь 30-34 насны эхээс, 13.3 хувь буюу 5206 нь 35-39 насны эхээс, 3.5 хувь буюу 1367 нь 40-44 насны эхээс, 0.2 хувь буюу 74 нь 45-аас дээш насны эхээс тус тус мэндэлжээ. 20-24 насны 1000 эмэгтэй тутмаас 153 хүүхэд, 25-29 насны 1000 эмэгтэй тутмаас 167 хүүхэд, 30-34 насны 1000 эмэгтэй тутмаас 132 хүүхэд, 35-39 насны 1000 эмэгтэй тутмаас 104 хүүхэд төрсөн байна.

Зураг 4. Хүүхэд төрүүлсэн эхчүүд, боловсролын түвшнээр



2016 онд хүүхэд төрүүлсэн эхчүүдийг боловсролын түвшнээр нь авч үзвэл 57.7 хувь буюу 21633 нь дээд болон түүнээс дээш, 37.1 хувь буюу 13907 нь бүрэн дунд, 1.7 хувь буюу 649 нь суурь, 1.9 хувь буюу 715 нь тусгай мэргэжлийн дунд болон техникийн мэргэжлийн, 0.3 хувь буюу 130 нь бага боловсролтой, үлдсэн 1.3 хувь буюу 474 нь ямар нэг боловсролгүй, эмэгтэйчүүд байна.

Хүүхэд төрүүлсэн эхчүүдийн 9.8 хувь буюу 3692 нь гэр бүлгүй, 90.2 хувь буюу 33816 нь гэр бүлтэй хүмүүс байна.

Хүснэгт 5. Төрсөн хүүхдийн тоо, дүүргээр, 2010-2016 он

Дүүрэг	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Багануур	657	753	850	762	803	644
Багахангай	98	103	106	109	177	92
Баянгол	4452	5002	5543	5803	7269	6178
Баянзүрх	6941	7530	8310	8404	9961	9265
Налайх	881	874	968	947	1059	860
Сонгинохайрхан	6883	7502	8171	8688	9636	8905
Сүхбаатар	3242	3430	3914	3889	4213	3515
Хан-Уул	3112	3471	3999	4450	4921	5140
Чингэлтэй	3960	4659	4560	4620	4751	4475
Нийслэлийн дүн	30226	33324	36421	37672	42790	39074
Улсын дүн	69853	73839	79780	82839	82130	79920
Улсын дүнд эзлэх хувь	43.3	45.1	45.7	45.5	52.1	48.9

ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Нийслэл хотын иргэдэд 2016 оны байдлаар эрүүл мэндийн салбарын үйлчилгээг 1898 байгууллагын нийт 25.3 мянган мэргэжилтнүүд үзүүлж байна. Тухайлбал 5986 их эмч, 1037 эм зүйч зэрэг 11012 дээд мэргэжлийн, 252 бага эмч, 513 лаборант, 376 гэрлийн техникч, 705 эм найруулагч, 5907 сувилагч, 288 эх баригч зэрэг 8336 дунд мэргэжлийн, бусад мэргэжлийн 5906 ажилчид ажиллаж, ард иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж байна.

Хүснэгт 6. Эрүүл мэндийн байгууллагын тоо


	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв	16	16	16	13	13	13
Дүүргийн нэгдсэн эмнэлэг	12	12	12	12	12	12
Амаржих газар	3	3	3	3	3	3
Өрхийн эмнэлэг	124	131	136	134	134	138
Хувийн эмнэлэг	860	675	631	751	778	
Рашаан сувилал	48	66	45	73	89	
Эмийн сан	374	477	373	469	461	

Улсын хэмжээнд эрүүл мэндийн байгууллагад ажиллагсдын 52.4 хувь буюу 25.3 мянган хүн Улаанбаатар хотын эрүүл мэндийн байгууллагуудад ажиллаж байна. Мөн их эмч нарын 59.9 хувь, эм зүйч нарын 65.4 хувь, эмнэлгийн дунд мэргэжлийн ажилтны 44.1 хувь нь тус тус нийслэл хотод ажиллаж байна.

Хүснэгт 7. Эрүүл мэндийн байгууллагын ажиллагчдын тоо

Мэргэжил	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Бүгд	20644	22399	23160	23923	24994	25254
үүнээс: эмэгтэй	17393	18510	18868	19724	20594	20838
Их эмч: Бүгд	4907	5359	5510	5793	5834	5986
үүнээс: эмэгтэй	3919	4217	4277	4709	4615	4730
Дотрын	541	544	569	708	658	632
Мэс заслын ба гэмтлийн	352	384	398	421	428	448
Эх барих эмэгтэйчүүдийн	373	406	418	419	451	472
Хүүхдийн	284	321	318	317	337	341
Халдвартын	187	147	146	125	182	182
Хавдар судлалын	44	43	43	36	31	32
Нүдний	90	85	104	97	97	103
Чих, хамар, хоолойн	75	95	89	86	86	101
Сүрьеэгийн	57	60	57	60	48	54
Арьсны	82	85	95	97	92	66
Рентгений	218	237	263	290	320	324
Мэдрэл, сэтгэл мэдрэлийн	273	280	272	301	287	291
Физик эмчилгээний	77	87	106	95	92	109
Стоматологийн	483	561	538	701	760	772
Лабораторын	205	232	239	228	219	227
Бусад мэргэжлийн	1566	1792	1855	1812	1746	1832
Эм зүйчид	1004	1153	1248	1208	1025	1037

Зураг 5. Нэг их эмчид ногдох хүний тоо, аймаг, нийслэлээр



2016 оны байдлаар нэг их эмчид 228 хүн, нэг сувилагчид 234 хүн ногдож байгаа нь бусад бүс нутаг, аймгуудаас ажлын ачаалал нь харьцангуй бага байна.

Хүснэгт . Эмнэлгийн дунд мэргэжилтний тоо


Мэргэжил	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Бүгд	6799	6604	7063	7563	7826	8075	8362	8336
Бага эмч	294	293	305	237	231	267	276	252
Эм найруулагч	1114	1117	1171	1291	1396	829	769	705
Лаборант	375	385	412	431	451	466	501	513
Сувилагч	4240	4396	4671	5003	5056	5598	5898	5907
Рентгений техникч	99	99	98	114	129	336	381	376

2016 онд улсын хэмжээнд 853.9 мянган хүн хэвтэж эмчлүүлсний 52.7 хувь буюу 450.2 мянган хүн Улаанбаатар хотын эмнэлгүүдэд хэвтэн эмчлүүлжээ. Эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн хүмүүсийн 27.8 хувь нь дотрын, 7.7 хувь нь мэс заслын, 14.5 хувь нь төрөх, 3.6 хувь нь эмэгтэйчүүдийн, 14.0 хувь нь хүүхдийн тасгаар эмчлүүлсэн байна.

Хүснэгт 9. Эрүүл мэндийн салбарын зарим үзүүлэлтүүд

	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Их эмчийн тоо	4907	5359	5510	5793	5834	5986
1 их эмчид ногдох хүний тоо	240	227	229	224	228	231
Эмнэлгийн орны тоо	9044	9456	9685	10614	11485	11835
1 оронд ногдох хүний тоо	131	129	129	122	116	115
Хэвтэж эмчлүүлсэн өвчтний тоо	333326	355218	370873	394989	417631	450184
Нялхсын эндэгдэл	450	486	546	625	613	611
Эхийн эндэгдэл	15	16	21	15	12	17
Үр хөндөлт	12338	13895	10385	11900	13164	13805

Зураг 6. Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд




Нийслэл хотод 2016 онд нэг хүртэл насны хүүхдийн эндэгдэл 611, эхийн эндэгдэл 17 гарчээ. Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас нэг хүртэл насандаа эндсэн хүүхдийн тоо 15.0 болж өмнөх оноос 0.7 промилээр, 2010 оноос 0.1 промилээр өсчээ. 2016 оны байдлаар эхийн эндэгдлийн 44.7 хувь, нэг хүртэл насандаа эндсэн хүүхдийн 46.5 хувь, халдварт өвчнөөр өвчилсөн тохиолдлын 57.7 хувь нь нийслэл Улаанбаатар хотод гарсан байна. 2016 онд халдварт өвчнөөр

өвчилсөн 40178 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оноос 0.7 пунктээр буурсан буюу 283 тохиолдлоор, 2010 оноос 1.9 дахин их буюу 18754 тохиолдлоор тус тус нэмэгдсэн байна. Халдварт өвчний гаралт өмнөх онуудтай харьцуулахад эрс нэмэгдсэн бөгөөд 15962 тохиолдол буюу 39.7 хувийг улаан бурхан өвчний тохиолдол дангаараа эзэлж байна.

Хүснэгт 10. Бүртгэгдсэн халдварт өвчин

	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Халдварт өвчнөөр өвчилсөн бүх хүн, үүнээс:	19955	25128	18739	18653	40461	40178
Вируст гепатит	4768	2718	1207	603	523	350
Менингит	9	14	17	5	6	5
Цусан суулга	1707	1726	1573	1921	2336	2448
Салхин цэцэг	1740	1578	2552	2305	3329	3696
Гахайн хавдар	477	6968	1487	188	159	249
Сальмонеллэз	77	78	49	72	105	164
Улаан эсэргэнэ	57	88	259	270	674	1268
Хоолны хордлого	147	633	121	235	376	386
Ёлом	123	145	109	104	104	120
Улаанууд	15	204	9	1	26	16
Бруцеллэз	63	34	14	17	17	19
Гар хөл амны өвчин	700	377	1262	1614	1205	4520
Улаан бурхан	-	-	-	-	19427	15962
Тэмбүү	2378	2764	3269	3618	4154	3086
Заг хүйтэн	1976	2219	1767	1650	2122	2023
Трихомониаз	1683	2030	1850	1723	1950	2080
Шинээр илэрсэн сүрьеэ	2283	2261	2401	2544	2537	2469
ХДХВ/ДОХ	17	27	23	31	18	26
Улсын хэмжээнд бүртгэгдсэн халдварт өвчин	42839	43305	37318	33516	59400	69663
Улсын хэмжээнд эзлэх хувь	46.6	58.0	50.2	55.7	68.1	57.7

Зураг 7. Халдварт өвчнөөр өвчлөгсөд



10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо өмнөх оноос 9.5 продицмилээр буурч, 2010 оноос 105.8 продицмилээр өсчээ.

Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 39.7 хувийг улаан бурхан, 11.2 хувийг гар хөл амны өвчин, 9.2 хувийг салхинцэцэг, 7.7 хувийг тэмбүү, 6.2 хувийг шинээр илэрсэн сүрьеэ, 6.1 хувийг цусан суулга, 5.2 хувийг трихомониаз, 5.0 хувийг заг хүйтэн өвчнөөр өвчлөгсөд тус тус эзэлж байна.